

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

**Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлж буй  
“ Нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж”**

/Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг/

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН



Улаанбаатар хот

2009 он

## АГУУЛГА

### **Нэгдүгээр хэсэг**

Хяналт-шинжилгээний арга зүй

Зорилго

Аргачлал, хамрах хүрээ

### **Хоёрдугаар хэсэг**

Иргэдийн ядуурлын төлөв байдал, хэрэгцээ шаардлага

### **Гуравдугаар хэсэг**

Хороодын нийгмийн халамжийн үйчилгээ үзүүлж буй нөхцөл байдал

### **Дөрөвдүгээр хэсэг**

Ерөнхий дүгнэлт, зөвлөмж

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

ХЭҮК-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2009 оны 10 сарын 13-14 ны өдрүүдэд Комиссын ажлын албаны дарга Д.Гэрэлчулуун, ахлах референт Ч.Отгончулуун, референт П.Баттөр, Б. Батцэцэг, Х.Мөнхзул, Б.Болорсайхан нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн зарим хороодын эмзэг бүлгийн иргэдэд үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмжийн байдалд хяналт- шинжилгээ хийв.

### **1. Хяналт- шинжилгээний арга зүй**

**Хяналт-шинжилгээний зорилго** нь Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмжийн чанар, түвшинг тодорхойлох, хүртээмжид сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх, зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авахуулахад оршино.

### **Хамрах хүрээ, түүвэрлэлт**

Энэхүү хяналт-шинжилгээний хамрах хүрээг тогтоохдоо нийслэлийн захын хороод болох хүн ам ихээр суурьшах, ядуурлын төвшин өндөр байх үзүүлэлтээр Нийслэлийн Баянзүрх дүүргийн 19, 21, 22, 24 дугаар хороод болон Сонгино Хайрхан дүүргийн 3, 4, 5, 22 дугаар хороодыг тус тус сонгон авав.

### **Хяналт - шинжилгээний аргачлал**

Хороодын үйл ажиллагаатай танилцах, бичиг баримтын шинжилгээ хийж тоон болон чанарын судалгааны аргыг хэрэглэв.

*Баримтын шинжилгээгээр* Монгол Улсын хууль тогтоомжинд нийгмийн халамжийн талаар тусгагдсан заалтуудад дүн шинжилгээ хийж, хороодын нийгмийн халамжийн асуудлаарх бичиг баримт, бүртгэл судалгаатай танилцав.

*Тоон судалгаанд /асуулга/ түүврийн аргаар* хороодын иргэдийг тусгайлсан асуумжинд хамруулж нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж буй байдал, халамжийн үйлчилгээний хүртээмж, иргэдийн сэтгэл ханамж, хэрэгцээ шаардлагыг болон нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах арга замуудыг судалсан болно.

Уг асуумжинд 400 гаруй иргэд хамрагдсанаас Сонгинохайрхан дүүргийн 180, Баянзүрх дүүргийн 185, нийт 365 иргэн асуумжид оролцсон.

*Чанарын судалгаанд* (уулзалт ярилцлага) тухайн хороодын Засаг дарга, нийгмийн ажилтнууд болон асуумжинд оролцсон иргэдээс нийгмийн халамжийн үйлчилгээг хүртэхэд учирч байгаа бэрхшээл, иргэдийн сэтгэл ханамж зэрэг асуудлаар санал бодолтой нь танилцав.

## 2. Сонгосон хороодын иргэдийн ядуурлын төлөв байдал, хэрэгцээ шаардлага.

Хороодын ядуурлын түвшинг авч үзвэл:

Дүүрэг	Нийт өрх	Ядуу өрх	Нэн ядуу өрх	Нийт дүн	Хувь
<b>Сонгино хайрхан дүүрэг</b>					
<b>22 хороо</b>	2424	524	100	624	26%
<b>3-р хороо</b>	2789	411	200	611	22%
<b>4-р хороо</b>	2683	658	131	789	29%
<b>5-р хороо</b>	2358	138	78	216	9%
<b>Баянзүрх дүүрэг</b>					
<b>21-р хороо</b>	3880	1876	540	2416	62%
<b>22-р хороо</b>	2900	1632	358	1984	68%
<b>19-р хороо</b>	2006	1840	111	1951	97%
<b>24-р хороо</b>	2104	586	315	901	43%

Үүнээс үзэхэд дүүрэг бүрт ядуу, нэн ядуу өрхийн эзлэх хувь харилцан адилгүй байна. Тухайлбал: Баянзүрх дүүргийн дээрх хороодын хувьд нийт өрхийн 60-70 хувь, Сонгино хайрхан дүүргийн өрхийн 20-30 хувь нь ядуу, нэн ядуу өрх байна.

Ийнхүү дүүрэг хороодод ядуурлын төвшин харилцан адилгүй байгаа нь дараах хүчин зүйлстэй холбоотой байна.

1 дүгээрт: Ядуу, нэн ядуу өрхийн статистикийн тоог гаргаж байгаа аргачлал зарим дүүрэг хороодод ялгаатай, нэгдсэн аргачлалгүй өөр өөр аргаар тооцож байна. Тухайлбал: Хороодод НХХЯ, ҮСГ-аас гаргасан аргачлал болон амьжиргааны баталгаажих доод төвшингөөр, цалин хөлсний хэмжээгээр нь хөдөлмөрийн чадвартай хүнийг хасаж тооцох зэрэг аргачлалаар тооцож байна.


2 дугаарт: Хөдөө орон нутгаас ирэх шилжилт хөдөлгөөн их байгаа холбоотой байна. Өөрөөр хэлбэл хөдөө орон нутгаас шилжин суурьшигчдын дунд ядуурлын төвшин өндөр байна. Жишээлбэл: Баянзүрх дүүргийн тухайн хороодод ядуурлын төвшин хамгийн өндөр байгаа бөгөөд хүн амын 60-70 хувийг хөдөө орон нутгаас шилжин суурьшигчид эзэлж байна.

3 дугаарт: Иргэдийн ажил эрхлэлтийн байдал нөлөөлж байна.

Иргэдээс авсан асуумжаас үзэхэд нийт асуумжинд оролцогчдын 68 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй байна./ Графикаар харуулав/


### **Асуулт 1.**

## Та ажил эрхэлдэг үү?



Асуулт-2

## Хэрэв та ажил эрхэлдэггүй бол амьжиргаагаа яаж залгуулдаг вэ?



Хороодын нийгмийн ажилтнуудаас ядуу иргэдийн амьжиргаагаа залгуулдаг арга замуудыг тодруулан үзвэл: газар шорооны ажил, мод түлээ, нүүрс бургас зарах, айлын ажил хийх / мод түлээ хагалах, ус зөөх/ цайны газар аяга таваг угаах, хоолны үлдэгдэл түүх, жимс, самар түүж борлуулах, хог лааз түүх, ах дүүгийн тусламж зэрэг арга замуудаар амьжиргаагаа залгуулж байна.

Ядуу, нэн ядуу иргэдийн хэрэгцээ, шаардлага ялгамжтай байна. Ядуу иргэдийн хувьд гол хэрэгцээ нь ажил хийх, ажлын байраар хангагдах явдал байна. Энэ нь ядуу хүмүүсийн хувьд ядуурлаас гарах гол арга зам хэдий ч өнөөгийн хөдөлмөрийн зах зээл дээр байгаа ажлыг хийхэд **мэргэжлийн боловсрол, ур чадвар** дутагдалтай байгаагаас гадна нас, хүйс, царай зүс, танил тал, бие бялдар, хувцас хунараар ялгаварлан гадуурхлалтай тулгардаг талаар тэд ярьж байна.

Мөн хувиараа хөдөлмөр эрхлэх замаар ядуурлаас гарахад хүү багатай, урт хугацааны зээл шаардлагатай ч зээлэнд хэрхэн яаж хамрагдах, төсөл бичих арга замаа хангалттай сайн мэдэхгүй байна.

Нэн ядуу иргэдийн хувьд нэн тэргүүний хэрэгцээ нь хоногийн хоолны асуудал байна. Хорооноос эдгээр хүмүүсийг зээлэнд хамруулах талаар тодорхой ажил зохиодог ч “сургалтанд ирдэггүй, өнөө маргаашаа боддог, бэлэнчлэх сэтгэлгээтэй” гэж хорооны нийгмийн ажилтнууд ярьж байна.

Үүнээс үзэхэд хорооны нийгмийн ажилтнуудад нэн ядуу, ядуу иргэдтэй ажиллах тодорхой аргачлал байхгүй, эдгээр иргэдийг хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох замаар ядуурлаас гарахад нь туслахад чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдэд зуучлан хамруулах үйл ажиллагаа нь хороодод хангалтгүй хэрэгжиж байна.

### **3. Хороодын нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж буй нөхцөл байдал.**

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 25 дугаар зүйлд Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амжиргаатай байх эрхтэй. Ажилгүйтэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэйг зарлан тунхагласан.

Мөн Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт (10-р зүйл) болон Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид хүүхэд, эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь шаардлагатай нийгмийн халамжийн үйлчилгээг хүртэх эрхтэй болохыг тусгайлан баталгаажуулж өгсөн юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16. 11-т “гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалах”-аар заажээ.

Энэ үүргийнхээ хүрээнд 2005 онд батлагдсан “Нийгмийн халамжийн тухай” хуулиар Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүмүүсийг төрөөс нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах эрх зүйн үндэслэлийг тогтоож өгсөн байна. Энэхүү хуулиар төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээний төрөл, хамрах хүрээ, нийгмийн халамжийн санг бүрдүүлэх, зарцуулах журам, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлсон байна.

Мөн “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” тусгайлсан хуулиудыг батлан гаргаж төрөөс ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг нарийвчлан тогтоож өгсөн байна.

Түүнчлэн МУ-ын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйл, мөн хуулийн 15 дугаар зүйлд хүүхэд төрөөс тусламж авах, тэтгэвэр тэтгэмж, асрамж, халамж хүртэх эрхтэй болох талаар болон энэ талаар холбогдох байгууллагын хүлээх үүргийг тодорхойлж, мөн хүнд нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх нийгмийн халамж, тусламийн үйлчилгээний төрлийг тогтоосон.

Монгол улсын засгийн газрын 2008 оны 162 дугаар тогтоолоор “Нийгмийн халамжийн сангийн дүрэм”, “Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох журам”, “Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”, “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам”, “Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам” “Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам” “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”, “Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх журам”-ыг тус тус батлан гаргасан байна.

Эдгээрээс үзэхэд Олон Улсын гэрээ конвенцоор баталгаажсан нийгмийн халамж, тусламж үзүүлэх асуудлыг манай улсын хууль, тогтоомжоор нарийвчлан тусгаж, олон төрлийн халамжийн үйлчилгээг тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж хэлбэрээр бий болгосон байна.

**“Нийгмийн халамж” гэдэг нь** Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т зааснаар “Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд буюу “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, түүнчлэн 18 насанд хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн, олон хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг эхэд энэ хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлдэг.

Төрөөс дараахь 5 төрлийн 30 гаруй нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж байна. Тухайлбал:

1. Нийгмийн халамжийн тэтгэвэр:

- Ахмад настны тэтгэвэр
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр
- Өрх толгойлсон эрэгтэй, эмэгтэй хүний тэтгэвэр
- Тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэр

2. Нөхцөлт мөнгөн тэтгэмж:

- Ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох тэтгэмж
- Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж;
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж
- Хүүхдийн нөхцөлт мөнгөн тэтгэмж

3. Амьжиргаанд дэмжлэг үзүүлэх хөнгөлөлт, тусламж

- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж
- Орон сууцны хөлсний болон түлшний үнийн хөнгөлөлт
- Халамжийн цэцэрлэгийн үнийн хөнгөлөлт

- Протез, ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслэлийн хангамж;
  - Сэргээн засах үйлчилгээний зардлын хөнгөлөлт
4. Олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
- Зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гарахад нь туслах, энэ чиглэлээр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдэд зуучлан хамруулах;
  - Түр байрлуулан асрамжлах;
5. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ
- Хүүхдийн асрамжийн үйлчилгээ
  - Ахмадын асрамжийн үйлчилгээ

Бид энэхүү хяналт-шинжилгээгээр төрөөс үзүүлж буй бүх төрлийн нийгмийн халамжийн үйлчилгээг судлах боломжгүй тул эдгээрээс иргэдэд хамгийн их эрэлт хэрэгцээтэй болох дараах 3 төрлийн үйлчилгээг сонгов.

Үүнд:

1. Түлээ нүүрсний үнийн хөнгөлөлт
2. Нөхцөлт мөнгөн тэтгэмж буюу асрамжийн мөнгө
3. Орон байрны буюу гэр авах хүсэлтийг хангах болон мөнгөн тусламж үзүүлэх

### **Түлшний үнийн хөнгөлөлт**

Эмзэг бүлгийн нэн ядуу, ядуу амьдралтай бүх хүмүүст түлээ, нүүрсний асуудал гол хэрэгцээ байна.

Гэвч энэ хөнгөлөлтөнд эмзэг бүлгийн бүх хүмүүс хамрагдаж чаддаггүй байна.

Учир нь түлшний үнийн хөнгөлөлтийг Нийгмийн халамжийн хуулиар дараах шаардлагыг хангасан хүмүүст олгохоор заасан.

- Бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- Тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд болон хүндэт донорт жилд нэг удаа 140.000 төгрөг олгогдог байна.

Үүнээс үзэхэд түлшний үнийн хөнгөлөлтөд хамрагдах хүсэлтэй дээрх нэн ядуу болон ядуу өрхөд хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настан байхгүй бол энэ тусламж хөнгөлөлтийг эдлэж чаддаггүй байна.

Ахмад настны хувьд тэжээн тэтгэх үр хүүхэдгүй, хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй гэж хуульд заасан хэдий ч практик дээр хууль ёсны үр хүүхэдтэй гэдэг үндэслэлээр хүсэлтийг нь буцаах явдал нэлээд гардаг



байна. Тухайлбал Сонгинохайрхан дүүргийн 22 хорооны 215 хүн түлээ нүүрсний мөнгө авахаар хүсэлт гаргаснаас 129 шийдвэрлэгдэж 86 хүсэлт хасагдсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд хөдөлмөрийн чадвар алдалтын 70 хувьдаа хүрээгүй, эмнэлгийн магадлагаа хийлгээгүй, байнгын асаргаа шаардлагагүй байна гэсэн үндэслэлээр хасагддаг байна.

**Нөхцөлт мөнгөн тэтгэмж :**

Халамжийн энэ төрөл нь:

- Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч буй иргэнд олгох тэтгэмж
- Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж буй иргэнд олгох тэтгэмж
- Хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг гэр бүлдээ авч халамжилж буй иргэн
- Тэжээн тэтгэх хүүхэдгүй, төрөл садангүй ганц бие ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гэр бүлдээ асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж гэсэн төрөлтэй байна.

Эдгээр нөхцөлт мөнгөн тэтгэмжийн төрлүүдээс байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмжийн шийдвэрлэлтийн байдлыг хүснэгтээр авч үзвэл:

**Сонгинохайрхан дүүрэг:**

2009 оны 09 сарын байдлаар

№	Хороо	22 хороо	3 хороо	4 хороо	5 хороо
1	Нийт ахмад настан	109	758	870	958
2	Байнгын асаргаа шаардлагатай ахмад	38	12	38	100
3	Өргөдөл гаргасан	37	12	38	20
4	Шийдвэрлэсэн	30	12	38	20
5	Буцсан	7	-	-	-

9	Шийдвэрлэгдээгүй шалтгаан	үндсэн хаягийн бүртгэлгүй-2 Хаягтаа байдаггүй-3 Харж хандах үр хүүхэдтэй-2	-	-	-
---	---------------------------	--	---	---	---

### Баянзүрх дүүрэг

№	Хороо	21 хороо	22 хороо	19 хороо	24 хороо
1	Нийт Ахмад настан	790	598	402	336
2	Байнгын асаргаа шаардлагатай ахмад	6	52	27	24
3	Өргөдөл гаргасан	6	52	27	24
4	Шийдвэрлэсэн	6	52	27	24
6	Буцсан	-	-	-	-
8	Шийдвэрлэгдээгүй шалтгаан	-	-	-	-

Тоон мэдээллээс үзэхэд байнгын асаргаа шаардлагатай ахмадын тоотой харьцуулахад түүнийг асарч буй иргэнд олгож буй тэтгэмжийн хүсэлт хангагдсан мэт харагдаж байна.

Нийгмийн халамжийн тухай хуульд ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж нь эмнэлгийн хяналтанд байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагын улмаас хөдөлмөр эрхэлдэггүй хүнд олгогдохоор заасан байна.

Гэвч хороодын судалгаанаас үзэхэд байнгын асаргаа шаардлагатай хүнийг асардаг хүмүүсийн хичнээн нь хөдөлмөр эрхэлдэг талаарх судалгаа алга байна.

Иймд байнгын асаргаа шаардлагатай хүнд олгогдож буй энэхүү тэтгэмж нь хэр хүртээмжтэй эсэх талаар дүгнэлт хийх боломжгүй байна.

Тэжээн тэтгэх хүүхэдгүй, төрөл садангүй ганц бие ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гэр бүлдээ асрамжилж байгаа иргэдийн хувьд ямар нэгэн саадгүйгээр уг тэтгэмж нь олгогдож байна.

### **Орон байрны хэрэгцээ буюу гэр авах хүсэлт**

Хороодын “орон гэргүй иргэдийн судалгаа”-наас үзэхэд иргэдийн орон гэргүй болсон нь дараах шалтгаантай байна.

- Гэр орон нь шатсан
- Хөдөө, орон нутгаас шилжиж ирэхдээ тээврийн зардалгүйгээс гэрээ орхиж ирсэн
- Орон гэрээ хулгайд алдсан
- Архидалт зэрэг хүчин зүйлээс орон гэрээ зарсан
- Байгалийн гамшигт байдлаас орон гэрээ алдсан байна.

Иймд орон байрны бэрхшээлтэй эдгээр иргэд орон байртай болохын тулд гэр хүсэж өргөдлөө харьяалах хороондоо гаргадаг байна.

Гэтэл “Нийгмийн халамжийн тухай хууль”-д дараах нөхцөлд гэр авахад нь дэмжлэг үзүүлж нэг удаа 500.000 төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр заасан. Үүнд:

- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд
- Гэнэтийн аюул ослын улмаас гэр оронгүй болсон өрхөд олгохоор тусгасан байна.

Баянзүрх дүүргийн 22 дугаар хороонд гэхэд гэр хүссэн 200 гаруй хүсэлт байгаагаас 4 өрхөд олгогдсон байна.


Үүнээс үзэхэд орон байрны хэрэгцээ шаардлагатай иргэн бүр энэ дэмжлэгийг хүртэж чаддаггүй байна. Дүүрэг хорооноос олон улсын байгууллагатай хамтран ажиллах зээл тусламж зэрэг бүхий л шугамаар энэхүү хүсэлтийг хангахын төлөө ажиллаж байна.

Тухайлбал: Баянзүрх дүүргийн 19 хороо энэ зуны үерт нэрвэгдсэн 78 өрхөд дүүргийн засаг даргын нөөцөөс гэр олгожээ.

### **4.Нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж**

Иргэдээс авсан асуумжаар нийгмийн халамжийн үйлчилгээ зохих хүмүүсдээ хүрч чадаж буй эсэхийг тодруулахад 72 хувь нь үгүй гэж хариулжээ.

**Асуулт 13. Хорооноос болон дүүргээс үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээ зохих хүмүүстэй хүрч чаддаг уу?**



Нийгмийн халамжийн үйлчилгээ зохих хүмүүсдээ хүрч чадахгүй, хүртээмжгүй байгаа нь дараах илэрсэн нөхцөл байдалтай холбоотой байна.

1. Хороодын нийгмийн халамжийн үйлчилгээний бүртгэл, судалгаа хангалтгүй байна.

Хороодын халамжийн үйлчилгээний бүртгэл, судалгаа нь халамжийн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай иргэдийг бүрэн тодорхойлох боломжгүй, өрх нэг бүрийн нарийвчилсан судалгаа зарим хороодод хийгдээгүй байна.

Тухайлбал: Баянзүрх дүүргийн 19 хорооны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаанаас үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс хичнээн нь тулах эрхтэний бэрхшээлтэй гэдгийг гаргаагүйгээс хэдэн хүнд тэргэнцэр шаардлагатай гэдгийг нь тодорхойлох боломжгүй байна.

2. Нийгмийн халамжийн үйлчилгээг хэрхэн авах талаарх иргэдийн мэдээлэл хомс, мэдээллийг түгээх арга хэлбэр хангалтгүй байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд иргэдийг хамруулахдаа ихэвчлэн тухайн үйлчилгээг авахаар хүсэлт гаргасан, халамжийн үйлчилгээний талаар мэдээлэл авсан хүмүүсээр л хязгаарлагдаж байна. Мэдээлэл авч чадаагүй хүмүүс халамжийн үйлчилгээнд үндсэндээ хамрагдаж чадахгүй байна.

Хорооны нийгмийн ажилтнууд өрх нэг бүрийн нөхцөл байдалтай танилцдаггүй, мэдээллийг ихэнх тохиолдолд хэсгийн ахлагчаар дамжуулан түгээдэг талаар иргэд гомдолтой байна. 1 хэсгийн ахлагчид дунджаар 300-500 өрх оногдож байгаагаас тэд айл нэг бүрээр орж чаддаггүй, зар мэдээллээ худаг, дэлгүүр зэрэг олон нийтийн газраар дамжуулж түгээдэг нь халамжийн үйлчилгээ зайлшгүй

шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг иргэдэд төдийлөн хүрч чаддаггүй байна.

3. Нийгмийн халамжийн чиглэлээр явуулж буй үйл ажиллагаа төрийн бодлого хөтөлбөрийн талаар иргэдэд сурталчлан таниулах ажиллагаа хангалттай хийгдээгүйгээс иргэд халамжийн үйлчилгээнд үл итгэх нөхцөл байдал үүссэн байна.


Тухайлбал: Нийгмийн халамжийн үйлчилгээ зохих хүмүүст хүрч чадахгүй байгаагийн шалтгааныг асуумжинд оролцсон иргэдээс тодруулахад хорооны даргын үзэмжээр шийдвэрлэгддэг 31,8 хувь, танил тал хардаг 22 хувь, тэгш бус хувиарладаг 12 хувь, мэдээлэл байхгүй 11 хувь нь тус тус хариулсан байна.

Дүүрэг хорооноос иргэдэд үйл ажиллагаагаа сурталчлах чиглэлээр нээлттэй өдөрлөг зэрэг арга хэмжээг зохиодог ч энэ нь хэсэг бүлэг хүмүүст л хүрэхээс бус уг мэдээлэл шаардлагатай хүмүүст буюу байнгын хэвтэрт байгаа, хог түүж амьдарч байгаа зэрэг эмзэг бүлгийнхэнд хүрч чаддаггүй байна.

4. Хороодод бичиг баримтын зөрчилтэй, огт баримт бичиггүй иргэд цөөнгүй байх бөгөөд эдгээр нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна.

Иргэдээс авсан асуумжаас үзэхэд хороондоо бүртгэлгүй иргэд нийт асуумжинд оролцсон иргэдийн 15.9 хувийг эзэлж байна.


### Асуулт-3



Мөн хороондоо бүртгэлтэй ч бичиг баримтгүй хүмүүс нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаггүй байна. Тухайлбал, Нийслэлийн Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороонд 43 иргэн огт бичиг баримтгүй байна. Эдгээр 43 иргэдийн хэд нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах шаардлагатай талаарх тоо баримт алга байна.

Хороодын үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээнд иргэд хэр сэтгэл ханамжтай байгааг тандах зорилгоор нийгмийн халамжийн үйлчилгээнд ямар дүн тавих бэ? гэсэн асуумжинд иргэдийн 49 хувь нь хангалтгүй, 34 хувь нь мэдэхгүй байна, 14 хувь нь хангалттай, 3 хувь нь хариулаагүй байна. Үүнээс үзэхэд иргэд нийгмийн халамжийн үйлчилгээнд сэтгэл ханамжгүй байна.

**. Та дүүрэг, хорооноос үзүүлж буй халамжийн үйлчилгээнд ямар дүн тавих вэ?**



Ялангуяа иргэдийг зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох чиглэлээр хэрэгжих төсөл хөтөлбөрүүдэд зуучлан хамруулах зэрэг үйлчилгээ нь хороодод хангалтгүй байгаа талаар иргэд ярьж байна.

Мөн иргэдийг хүлээн авч уулзах тусгай өрөө тасалгаа байхгүй, 1 өрөөнд 4-5 хорооны ажилтан байдаг тул иргэд тэр бүр тав духтай үйлчлүүлж чаддаггүй байна.

Хороодын барилга, байгууламж, өрхийн эмнэлэг нь гадна талдаа налуу замгүйгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэх хүртээмжтэй орчинг бүрдээгүй байна.

Нийгмийн ажилтнууд зайлшгүй шаардлагатай компьютер, канон, зургийн аппарат зэрэг техник хэрэгслээр бүрэн хангагдаагүй нь тэдний ажлын бүтээмжинд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Хяналт-шинжилгээний дүнд Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн халамжийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1. Хороодын иргэдэд мэдээлэл түгээх арга хэлбэрийг хүртээмжтэй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээний талаарх бодлого шийдвэрийг сурталчилан таниулах ажлын хамрах хүрээг өргөжүүлэх.
2. Хороодын нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн бүртгэл, судалгааг гаргах нэгдсэн стандарт бий болгох.
3. Иргэний бичиг баримтгүй, хогын цэг дээр амьдардаг, оршин суух тодорхой хаяггүйгээс нийгмийн халамжийн үйлчилгээг хүртэж чадахгүй иргэдийн асуудалд онцгой анхаарч тэднийг нэгдсэн бүртгэлд бүртгэж нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах ажлыг эрчимжүүлэх.

4. Хороодын халамжийн болон хөгжлийн нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх чиглэлийн сургалтанд тогтмол хамруулж, чадавхижуулах, ажлын байранд шаардагдах техник хэрэгслээр хангах.
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудын үйлчлүүлэх орчныг бүрдүүлэх зорилгоор хороодын ажлын байрны тасалгаануудын хаалгыг босгогүй болгох, гадна хаалгыг саадгүй нэвтрэх боломжтой хэлбэрээр /налуу зам/ засварлах.

Тайлан бичсэн:

Ахлах Референт.....Ч.Отгончулуун  
Референт ..... Х.Мөнхзул

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## Хавсралт

Хяналт-шинжилгээнд хамрагдсан хороонуудын тус бүрийн танилцуулга бүтэц, бүрэлдэхүүн, статистик тоо мэдээлэл:

### **а/ Сонгинохайрхан дүүргийн 22 –р хороо:**

Хороо нь 2424 гаруй өрхтэй, 10279 гаруй хүн амтай. Тус хороонд Сонгинохайрхан дүүргийн хамгийн эмзэг бүлгийн иргэд амьдардаг бөгөөд дүүргийн нутаг дэвсгэрийн хамгийн зүүн захад буюу Толгойтын хилийн цэргийн 05 дугаар ангийн хойд талд байрлалтай.

Хүн амын статистик тоон үзүүлэлт:

өрх толгойлсон эмэгтэй 109, эрэгтэй 55,  
байнгын асаргаа шаардлагатай иргэн 38,  
бүтэн өнчин 6 хүүхэд,  
хагас өнчин хүүхэд 53,  
70 дээш насны ахмад 109,  
орон гэргүй 14 хүн,  
гадаадад сурдаг, ажилладаг 83, оюутан 48 байна.

### **б/ Сонгоно хайрхан дүүргийн 3 –р хороо:**

Тус хороо нь 117.5 га нутаг дэвсгэрт 2789 өрхийн 13033 хүн амтай. Нийт хүн амыг Насны бүлгээр авч үзвэл:  
хүүхэд /0-17/ насны-4886  
залуу /18-35/ насны-2688  
дунд /36-55/ насны 3895  
ахмад өндөр настай /60-дээш 758

Хороонд нийслэлийн тэргүүний 65 дугаар сургуульд 2997 хүүхэд суурь боловсролыг эзэмшиж, нийслэлийн тэргүүний 80 дугаар цэцэрлэгт 430 гаруй хүүхэд сургуулийн өмнөх боловсролыг эзэмшиж, 50 гаруй ААНБ, 150 гаруй жижиг үйлдвэрлэл эрхлэгчид үйл ажиллагаа явуулж байна.

### **в/ Сонгино хайрхан дүүргийн 4-р хороо**

Тус хороо нь 12955 хүн амтай, 2683 өрхтэй. Үүнээс 658 ядуу өртэй, 8 хэсэгтэй. Ахмад настай 870, бүтэн өнчин 23, сургууль завсардсан 32 хүүхэд, ХБХ 38, хөдөлмөр эрхэлдэг 10 хүүхэд, өрх толгойлсон эмэгтэй 79, эрэгтэй 7 хүн тус тус амьдарч байна.

ОИН.МН  
СУДАЛГААНЫ САН



**г/ Сонгино хайрхан дүүргийн 5 –р хороо**

Тус хороо нь 10900 хүн амтай, 2358 өрхтэй. Хүн амын 20 хувь нь орон сууцанд, үйлдсэн 80 хувь нь гэр хороололд амьдардаг. Хорооны нутаг дэвсгэрийн ихэнх хэсгийг намаг ихтэй газар эзэлдэг тул хүн амын дунд шилжилт хөдөлгөөн ихтэй.

Хүн амын статистик тоон үзүүлэлт:

нэн ядуу өрх 78,

ядуу өрх 138

орон гэргүй өрх 16,

бүтэн өнчин хүүхэд 22,

хагас өнчин өнчин хүүхэд 67,

хөдөлмөр эрхэлдэггүй иргэнт 213,

хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэг 181,

өндөр настан 429,

өрх толгойлсон эмэгтэй, эрэгтэй 442 оршин сууж байна.

**д/ Баянзүрх дүүрэг 21 –р хороо**

Тус хороо нь 3880 өрхтэй, 17000 хүн амтай. Улаанбаатар хотын хамгийн их хүн амтай хорооны нэгд тооцогддог. Хүн амын 70 хувь нь эмзэг бүлгийн хөдөө орон нутгаас шилжиж ирсэн хүмүүс байдаг.

Хүн амын статистик тоон үзүүлэлт:

ядуу өрх 1876,

нэн ядуу өрхөд амьдарч буй хүүхэд 205,

хөгжлийн бэрхшээлтэй иргэн 258, үүнээс хүүхэд 16,

хагас өнчин хүүхэд 164,

бүтэн өнчин хүүхэд 20,

өрх толгойлсон эмэгтэй 411, эрэгтэй 397,

ахмад настан 79,

гэр оронгүй өрх 62,

сургууль завсардсан хүүхэд 19,

хөдөлмөр эрхэлдэг хүүхэд 6 тус тус байна.

**е/ Баянзүрх дүүргийн 22-р хороо**

Тус хороо нь 2900 өрх, 12000 хүн амтай. 398,30 га талбай бүхий газар нутагтай. Хорооны нутаг дэвсгэрт нэг ч сургууль, цэцэрлэг, эмнэлэг байхгүй, ЕБС-д суралцдаг хүүхдүүд 3,7-8 км явган явж өөр хорооны нутаг дэвсгэрт байрлах сургуульд суралцдаг. Хорооны ихэнх иргэд орон нутгаас ирж суурьшсан учир бичиг баримтын зөрчил ихтэйн улмаас хөдөлмөр эрхлэх боломж муу байдаг. Хорооны ихэнх хөдөлмөр эрхэлдэггүй иргэн модны Цайз зах дээр мод хагалж, шуудайлж өдрийн орлогоо олж амьдардаг. Хорооны нийт иргэйд 70 хувь нь бага орлоготой буюу ядуу хүмүүс байна.


Амжиргааны төвшний талаар авч үзвэл:

250 өрх боломжийн амьдралтай

560 өрх дундаж амьдралтай

1632 өр ядуу амьдралтай

358 өрх нэн ядуу амьдарч байна.



Хүн амын статистик тоон үзүүлэлт:

0-6 насны хүүхэд 1146,  
сургуулийн насны хүүхэд 3683,  
өрх толгойлсон эмэгтэй 297, эрэгтэй 57,  
өндөр настан 598,  
хагас өнчин хүүхэд 113,  
бүтэн өнчин хүүхэд 17,  
хөгжлийн бэрхшээлтэй иргэн 258,  
хөдөлмөр эрхэлдэггүй иргэн 1842,  
орон гэргүй хүн 62,  
сургуулийн өмнөх насны хүүхэд 426,  
асрамж халамжийн үйлчилгээний төвд 25 хүүхэд амьдарч байна.

#### **ё/ Баянзүрх дүүргийн 19-р хороо**

Тус хороо нь 9240 хүн амтай, 2006 өрхтэй, Үүнээс 1840 өрх нь ядуу амьдралтай байна. Хорооны нийт өрхийн 90 гаруй хувь нь гэр хороололд амьдардаг. Мөн сүүлийн үед хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийн тоо нэмэгдэх хандлагатай байна. Сургууль цэцэрлэг тус хороонд байхгүй. Энэ жил үерт 450 өрх нэрвэгдэж үүнээс 65 өрх гэргүй болсоныг гэртэй болгосон байна.

Хүн амын статистик тоон үзүүлэлт:

1840 өрх нь ядуу,  
ахмад настан 402, үүнээс байнгын асаргаанд 27,  
хөгжлийн бэрхшээлтэй иргэн 205, хүүхэд 22  
бүтэн өнчин хүүхэд 19,  
хөдөлмөр эрхлэдэг хүүхэд 3,  
хагас өнчин хүүхэд 38,  
эмзэг бүлгийн хүүхэд 29,  
өрх тойлгойлсон эрэгтэй 6, эмэгтэй 99,  
сургууль завсардсан 5 хүүхэд,  
ганц бие ахмад настай 3,  
хөдөлмөр эрхэлдэггүй иргэн 1767 байна.

#### **ж/ Баянзүрх дүүргийн 24-р хороо**

Тус хороо нь 2104 өрхийн 8158 хүн амтай. 198,5 га нутаг дэвсгэртэй, 7 хэсэгтэй. Хорооны нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ худалдааны үйл ажиллагаа явуулдаг 53 аж ахуйн нэгж, байгууллагатай. Нийт өрхийн 50 гаруй хувь нь хөдөө орон нутгаас ирж суурьшсан. Тус хороонд сургууль цэцэрлэг байхгүй, хүн амын 65 орчим хувь нь амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур орлоготой, эмзэг бүлгийн иргэд эзэлдэг.

Хүн амын статистик тоон үзүүлэлт:

Сургуулийн өмнөх насны 397, үүнээс цэцэрлэгт хамрагдалт 15 хувьтай  
Сургуулийн насны хүүхэд 1580  
0-16 насны хүүхэд 2135  
18-35 насны залуучууд 3111  
Ахмад настан 336 үүнээс ганц бие ахмад настан 23

UIH.MN  
САН

Хөдөлмөрийн насны 5196 иргэнээс 1970 ажилгүй,  
Өрх толгойлсон эрэгтэй 30, эмэгтэй 429  
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 185  
Бүтэн өнчин 7  
Сургууль завсардсан-9  
Ядуу, нэн ядуу 586 өрхийн 5100 иргэн байна.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН